



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/169/СТА-ТШЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p> | <p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

| | |
|--|----|
| Аудитын гэрчилгээ | 3 |
| Аудитын тайлан | 5 |
| 2.1. Оршил..... | 5 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага..... | 5 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 5 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 6 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 6 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар..... | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд..... | 7 |
| 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 8 |
| 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 8 |
| 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 8 |
| 2.13. Шилэн дансны мэдээлэл | 9 |
| 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 9 |
| 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 9 |
| Менежментийн захидал..... | 10 |
| 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан..... | 11 |
| 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 12 |
| 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 13 |
| 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 15 |
| 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 16 |
| 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан..... | 18 |

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

᠑᠙᠒᠐.᠐᠒.17 № 7/᠑᠒
танай _____-ны № _____-т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

БАЯНЦАГААН СУМЫН СУМ
ДУНДЫН ЭМНЭЛГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ОДОНТУНГАЛАГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020036


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Т.Одонтунгалаг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.26-аас 2020.01.28-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.13-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.13-ний өдрийн № 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай хүргэнэ” гэсэн эрхэм зорилго оршино.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Тус сум дундын эмнэлэг нь ард иргэдэд эрүүл мэндийн анхан шатны цогц тусламж үйлчилгээг шуурхай, жигд тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлэх, хүн бүрийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, эрүүл зөв дадлыг эзэмшүүлэх, төлөвшүүлэх, өвчлөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан үйлчлүүлэгчдийнхээ амьдралын чанарыг сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашиглаж байна.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 32 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 590,918.7 мянган төгрөгөөс тооцон 11,818.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 11,818.4 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24929,8 мянган төгрөгөөр буюу 5,8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөг/ | | |
|---|------------------|------------------|------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0 | 51.2 | 51.2 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 31,182.7 | 27,943.4 | -3,239.3 |
| Үндсэн хөрөнгө | 554,282.9 | 527,758.3 | -26,524.6 |
| Хуриатлагдсан элэгдэл | -177,931.7 | -173,148.7 | 4,782.9 |
| Нийт хөрөнгө | 407,534.0 | 382,604.2 | -24,929.8 |
| Өр төлбөр | 312.4 | 186.6 | -125.7 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 407,221.7 | 382,417.6 | -24,804.1 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 407,534.0 | 382,604.2 | -24,929.8 |

Авлага дансны үлдэгдэл 51,2 мянган төгрөгөөр өссөн нь шатахууны бэлтгэн нийлүүлэгчээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3239.3 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалын дансны 1886.3 мянган төгрөгөөр оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

Бараа материалын дансанд 2019 оны шинэ эмнэлэг ашиглалтад орсонтой холбогдуулан иргэдээс өгсөн хандивын үнэ төлбөргүй 1913.0 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 26524,6 мянган төгрөгөөр буурсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 9390,0 мянга, хандив тусламжаар 17810,3 мянган төгрөг нэмэгдсэн бөгөөд 53724,9 мянган төгрөгийн хөрөнгө акталсан.

Үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 13000,0 мянган төгрөгийн уурын зуухны барилгыг аймгийн ИТХ-ын 2019 оны 130 дугаар тогтоолоор, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын дансанд бүртгэлтэй 40724,9 мянган төгрөгийн хөрөнгийг Баянцагаан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 24 тоот тогтоолоор акталж устгасан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь 2018 онд үүссэн өрийг бүрэн барагдуулснаас шалтгаалсан бөгөөд аудитын залруулгаар 186,6 мянган төгрөгийн ҮЭ-ийн өглөгийг нэмж тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 382417,6 мянган төгрөг болж 24804,1 мянган төгрөгөөр буурсан нь тайлан үеийн үр дүн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг нь тайлант онд өөрийн орлого төлөвлөөгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 547062,7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 538062,7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Тайлант онд нийт 547,1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 488,6 сая, ЭМД-ийн сангаас 58,5 сая төгрөг авахаар батлагдсан ба гүйцэтгэлээр 545,9 сая төгрөгийн санхүүжилт буюу улсын төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч ЭМДС-аас 57,4 сая төгрөг авч 1,1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна. Оны эцэст хэмнэгдсэн зарцуулаагүй зардлын үлдэгдэл 32448,3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 513502,8 мянган төгрөг буюу 9,39 хувьтай байгаагаас гол хэмнэгдсэн зардал нь цалин түүнтэй адилтгах орлого 9,6 сая, тогтмол зардал 13,3 сая, хангамж материалын зардал 4,3 сая эд хогшил худалдан авах зардал 1,5 сая нийт 33,6 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна. Цалингийн зардал хэмнэгдсэн шалтгаан нь багийн эмч жирэмсний амралт авсан, халаалтын зардал хэмнэгдсэн нь шинэ эмнэлгийн барилгыг жилийн турш ажиллахаар төлөвлөсөн боловч 2019 оны 10-р сараас эхэлж ашиглаж эхэлсэнтэй холбоотой байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 905,2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 186,6 мянган төгрөгийн алдаанд залруулга хийж, 718,6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 186,6 мянган төгрөгийн алдаа илэрсэнд санхүүгийн тайланд залруулга хийсэн. Үүнд:

1. Цалингийн тооцооллыг давтан шалгахад цалингаас суутгасан ҮЭ-ийн 186,6 мянган төгрөгөөр суутгалыг шилжүүлээгүй байхад өглөгөөр тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.3.бүх өр төлбөр заалттай нийцэхгүй, "эрх үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Залруулсан.

Аудитаар илэрсэн 718,6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Байршуулаагүй |
|-----|------------|-------|------|-----------------------|-----------------------------|---------------|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 11 | 0 | 0 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 92 | 4 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 147 | 4 | 0 |

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар: Зөвлөмж өгөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлыг 718,6 мянган төгрөгөөр ажил олгогчоос төлөх НДШ-ээс гүйлгэн зарцуулсан.

1.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй

1.3. Өгсөн зөвлөмж:

Зардлыг хуульд заасан хувь хэмжээг харгалзан үзэж бодитой төлөвлөн зардал гаргахдаа Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>31,182,670.54</u> | <u>27,994,606.54</u> |
| 33 | АВЛАГА | 00.00 | 51,230.00 |
| 335 | Бусад авлага | 00.00 | 51,230.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 51,230.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 31,182,670.54 | 27,943,376.54 |
| 354 | Хангамжийн материал | 27,672,670.54 | 24,713,376.54 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 345,650.00 | 345,650.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,076,277.00 | 12,831,277.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 410,000.00 | 00.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,589,300.00 | 1,171,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,251,443.54 | 10,365,149.54 |
| 35600 | Мал амьтад | 3,510,000.00 | 3,230,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>376,351,374.03</u> | <u>354,609,615.23</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 376,351,374.03 | 354,609,615.23 |
| 392 | Биет хөрөнгө | 361,853,374.03 | 340,111,615.23 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 275,786,430.24 | 275,786,430.24 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -120,000.00 | -17,665,718.28 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 62,848,002.00 | 57,866,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -34,575,676.54 | -36,125,180.90 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 185,717,943.72 | 148,770,331.72 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -132,770,861.40 | -107,647,275.88 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,982,615.90 | 30,387,151.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,015,079.89 | -11,260,557.57 |
| 393 | Биет бус хөрөнгө | 14,498,000.00 | 14,498,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,948,000.00 | 14,948,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>407,534,044.57</u> | <u>382,604,221.77</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>312,368.00</u> | <u>186,649.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 312,368.00 | 186,649.00 |
| 413 | Өглөг | 312,368.00 | 186,649.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 312,368.00 | 186,649.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>407,221,676.57</u> | <u>382,417,572.77</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 407,221,676.57 | 382,417,572.77 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 285,452,863.00 | 285,452,863.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 285,452,863.00 | 285,452,863.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -206,245,546.58 | -231,049,650.38 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -206,245,546.58 | -206,245,546.58 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -24,804,103.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 328,014,360.15 | 328,014,360.15 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>407,534,044.57</u> | <u>382,604,221.77</u> |

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/ |
|-------------|--|-----------------------|--------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 453,569,759.08 | 566,114,577.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,839,818.08 | 19,735,277.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,239,732.98 | 19,735,277.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,410,132.98 | 19,735,277.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,000.00 | 12,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,398,132.98 | 19,723,277.00 |
| 120009 | Бусад орлого | 829,600.00 | 00.00 |
| 122 | Тусламжийн орлого | 6,600,085.10 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 6,600,085.10 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 444,729,941.00 | 546,379,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 367,623,200.00 | 488,558,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 367,623,200.00 | 488,558,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 37,118,532.00 | 440,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,118,532.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 440,200.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 39,988,209.00 | 57,381,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 39,988,209.00 | 57,381,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 471,719,390.55 | 580,870,763.81 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 471,719,390.55 | 580,870,763.81 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 426,188,255.55 | 547,782,742.81 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 279,490,282.00 | 343,350,566.00 |
| 210101 | Үндсэн цалин | 189,102,357.00 | 219,620,341.00 |
| 210102 | Нэмэгдэл | 73,507,596.00 | 95,020,795.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 4,904,483.00 |
| 210104 | Урамшуулал | 16,880,329.00 | 23,804,947.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,508,455.00 | 43,763,910.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,311,818.00 | 29,279,839.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 796,760.00 | 3,444,689.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 643,167.00 | 2,755,747.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 163,191.00 | 687,734.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,593,519.00 | 7,595,901.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,631,699.00 | 37,984,873.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,496,455.00 | 1,734,679.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,024,124.00 | 36,088,250.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 111,120.00 | 161,944.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,898,390.98 | 33,167,354.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,337,500.00 | 2,358,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,692,930.00 | 19,569,760.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 50,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 982,600.00 | 2,619,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,885,360.98 | 8,570,094.00 |
| 2105 | Нормативт зардал | 37,129,004.00 | 42,179,237.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 31,249,304.00 | 35,927,837.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,144,700.00 | 6,146,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 735,000.00 | 105,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,042,000.00 | 2,042,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 119,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 923,000.00 | 2,042,300.00 |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 658,000.00 | 1,217,000.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 658,000.00 | 1,217,000.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,404,987.00 | 2,897,884.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 300,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 390,875.00 | 346,650.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 101,300.00 | 73,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 39,534.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,306,800.00 | 1,306,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46,012.00 | 38,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 242,000.00 | 228,500.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 318,000.00 | 314,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,425,437.57 | 41,179,618.81 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,767,817.00 | 2,285,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,657,620.57 | 38,894,118.81 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,531,135.00 | 33,088,021.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 37,118,532.00 | 600,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 37,118,532.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 600,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,412,603.00 | 32,448,321.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,412,603.00 | 32,448,321.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 39,700.00 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 00.00 | 39,700.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -18,149,631.47 | -14,756,186.81 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 374,674.74 | 10,047,916.99 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 10,047,916.99 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 374,674.74 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -374,674.74 | -10,047,916.99 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -18,524,306.21 | -24,804,103.80 |

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 445,571,541.00 | 546,391,300.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 841,600.00 | 12,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 841,600.00 | 12,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,000.00 | 12,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,000.00 | 12,000.00 |
| 120009 | Бусад орлого | 829,600.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 444,729,941.00 | 546,379,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 367,623,200.00 | 488,558,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 367,623,200.00 | 488,558,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 37,118,532.00 | 440,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,118,532.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 440,200.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 39,988,209.00 | 57,381,000.00 |

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 39,988,209.00 | 57,381,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 445,571,541.00 | 537,001,300.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 445,571,541.00 | 537,001,300.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 400,040,406.00 | 503,913,279.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 279,177,914.00 | 343,476,285.00 |
| 210101 | Үндсэн цалин | 188,789,989.00 | 219,433,692.00 |
| 210102 | Нэмэгдэл | 73,507,596.00 | 95,333,163.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 4,904,483.00 |
| 210104 | Урамшуулал | 16,880,329.00 | 23,804,947.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,508,455.00 | 43,763,910.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,439,084.00 | 29,279,839.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,014,288.00 | 3,444,689.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 818,763.00 | 2,755,747.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 207,745.00 | 687,734.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,028,575.00 | 7,595,901.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,631,699.00 | 37,984,873.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,496,455.00 | 1,734,679.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,024,124.00 | 36,088,250.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 111,120.00 | 161,944.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,282,030.00 | 24,228,940.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,463,000.00 | 2,062,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,191,430.00 | 18,070,440.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 50,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,259,200.00 | 2,502,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,368,400.00 | 1,543,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 39,520,504.00 | 44,998,437.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 31,069,304.00 | 35,927,837.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,144,700.00 | 6,146,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,306,500.00 | 2,924,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,480,000.00 | 1,214,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 380,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,100,000.00 | 1,214,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 490,000.00 | 1,217,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 490,000.00 | 1,217,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,348,487.00 | 2,977,884.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 300,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 390,875.00 | 346,650.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 101,300.00 | 73,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 39,534.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,306,800.00 | 1,306,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46,012.00 | 38,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 242,000.00 | 228,500.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 261,500.00 | 394,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,601,317.00 | 4,051,650.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,601,317.00 | 4,051,650.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,531,135.00 | 33,088,021.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 37,118,532.00 | 600,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 37,118,532.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 600,000.00 |

| | | | |
|--------|--|--------------|---------------|
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,412,603.00 | 32,448,321.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,412,603.00 | 32,448,321.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 39,700.00 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 00.00 | 39,700.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 9,390,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 00.00 | 9,390,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 00.00 | 9,390,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 9,390,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 9,390,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 00.00 | -9,390,000.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|---|
| C08 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 285,452,863.00 | 328,014,360.15 | -206,245,546.58 | 00.00 | 407,221,676.57 |
| D01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 285,452,863.00 | 328,014,360.15 | -206,245,546.58 | 00.00 | 407,221,676.57 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 285,452,863.00 | 328,014,360.15 | -206,245,546.58 | 00.00 | 407,221,676.57 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -24,804,103.80 | 00.00 | -24,804,103.80 |
| D09 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 285,452,863.00 | 328,014,360.15 | -231,049,650.38 | 00.00 | 382,417,572.77 |

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 372,043,300.00 | 375,543,618.00 | 547,062,700.00 | 513,502,779.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 372,043,300.00 | 375,543,618.00 | 547,062,700.00 | 513,502,779.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 363,043,300.00 | 366,543,618.00 | 546,462,700.00 | 512,902,779.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 266,750,000.00 | 266,533,865.00 | 353,040,300.00 | 343,476,285.00 |
| 210101 | Үндсэн цалин | 200,079,000.00 | 202,463,853.00 | 224,385,200.00 | 219,433,692.00 |
| 210102 | Нэмэгдэл | 49,295,400.00 | 46,697,216.00 | 97,266,600.00 | 95,333,163.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 | 6,930,000.00 | 4,904,483.00 |
| 210104 | Урамшуулал | 17,375,600.00 | 17,372,796.00 | 24,458,500.00 | 23,804,947.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,874,800.00 | 29,874,800.00 | 44,130,000.00 | 43,763,910.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,874,800.00 | 29,874,800.00 | 29,120,400.00 | 29,279,839.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 3,752,400.00 | 3,444,689.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 3,001,900.00 | 2,755,747.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 750,500.00 | 687,734.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 7,504,800.00 | 7,595,901.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,579,700.00 | 11,563,145.00 | 51,287,500.00 | 37,984,873.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,480,700.00 | 1,555,345.00 | 2,894,800.00 | 1,734,679.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,893,200.00 | 9,802,000.00 | 47,752,700.00 | 36,088,250.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 205,800.00 | 205,800.00 | 640,000.00 | 161,944.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,166,400.00 | 12,161,764.00 | 28,881,700.00 | 24,579,240.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 466,800.00 | 465,000.00 | 2,466,800.00 | 2,062,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,580,400.00 | 10,577,764.00 | 19,544,900.00 | 17,970,740.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 183,700.00 | 183,700.00 | 240,000.00 | 50,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 445,500.00 | 445,300.00 | 2,530,000.00 | 2,502,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 490,000.00 | 490,000.00 | 4,100,000.00 | 1,993,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 38,079,000.00 | 37,414,664.00 | 47,568,100.00 | 44,998,437.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,953,100.00 | 30,289,764.00 | 38,442,200.00 | 35,927,837.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,145,900.00 | 5,145,300.00 | 6,145,900.00 | 6,146,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,980,000.00 | 1,979,600.00 | 2,980,000.00 | 2,924,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,232,600.00 | 2,227,200.00 | 11,700,000.00 | 10,154,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 396,000.00 | 390,600.00 | 900,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 | 9,000,000.00 | 8,940,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,836,600.00 | 1,836,600.00 | 1,800,000.00 | 1,214,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 531,300.00 | 518,000.00 | 1,800,000.00 | 1,217,000.00 |

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|---------------|---|----------------|----------------|----------------|----------------|
| 210702 | Дотоод албан томилолт | 531,300.00 | 518,000.00 | 1,800,000.00 | 1,217,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,334,500.00 | 1,307,100.00 | 3,105,100.00 | 2,677,084.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,500.00 | 500,000.00 | 250,000.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 138,600.00 | 138,500.00 | 515,000.00 | 346,650.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 79,200.00 | 62,500.00 | 160,000.00 | 73,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,700.00 | 33,000.00 | 72,000.00 | 39,534.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 | 1,306,800.00 | 1,306,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 38,000.00 | 38,000.00 | 110,800.00 | 38,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99,000.00 | 98,000.00 | 245,000.00 | 228,500.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 445,500.00 | 437,100.00 | 445,500.00 | 394,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 495000.00 | 4943080.00 | 4950000.00 | 4051650.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 495,000.00 | 4,943,080.00 | 4,950,000.00 | 4,051,650.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9000000.00 | 9000000.00 | 600000.00 | 600000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 9,000,000.00 | 9,000,000.00 | 600,000.00 | 600,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,000,000.00 | 9,000,000.00 | 600,000.00 | 600,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 376,498,300.00 | 375,093,142.00 | 547,062,700.00 | 513,502,779.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 345,498,300.00 | 345,489,502.00 | 488,558,100.00 | 456,121,779.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 345,498,300.00 | 345,489,502.00 | 488,558,100.00 | 456,121,779.00 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 29,600,000.00 | 29,598,780.00 | 58,504,600.00 | 57,381,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 29,600,000.00 | 29,598,780.00 | 58,504,600.00 | 57,381,000.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,400,000.00 | 4,860.00 | 00.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,400,000.00 | 4,860.00 | 00.00 | 00.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 30.00 | 30.00 | 30.00 | 30.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 23.00 | 23.00 | 23.00 | 23.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 | 06.00 | 06.00 |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | 1,200.00 | 1,200.00 | 1,998.00 | 1,998.00 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | 237.00 | 237.00 | 379.00 | 379.00 |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо | 963.00 | 963.00 | 1,619.00 | 1,619.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 30.00 | 30.00 | 30.00 | 30.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 17.00 | 17.00 | 19.00 | 19.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 13.00 | 13.00 | 11.00 | 11.00 |

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|------------|--|--------------------|------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 37118532.00 | 400,500.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 37118532.00 | 400,500.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 37118532.00 | 400,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 440200.00 | 400,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 440200.00 | 400,500.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 37118532.00 | 400,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 37118532.00 | 400,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37118532.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 400,500.00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Б.АЗБАЯР 2020.02.14

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ 2020.02.14

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ 2020.02.14

